



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

Халдварын сэргийлэлт, хяналтын  
тогтолцоог бэхжүүлэх зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолын 3.2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх үйл ажиллагааг үнэлэх хяналтын хуудсыг нэгдүгээр, эмнэлгийн тархвар судлаачийн ажлын байрны тодорхойлолтын загварыг хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагын тасаг нэгжид халдвар, хяналтын асуудал хариуцсан ажилтны ажлын чиг үүргийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг мөрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар, клиник, сувилал, төвүүдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын Дөрөвийн 4.3, 4.4, 4.5, хоёрдугаар хавсралтын Зургаагийн 6.13, 6.14, дөрөвдүгээр хавсралтын Дөрөвийн 4.2, 4.3, 4.4, тавдугаар хавсралтын Зургаагийн 6.2, 6.3, 6.4 дахь заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 04 сарын 27-ны өдрийн  
А. дугаар тушаалын 1 дүгээр  
169 хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Энэхүү хяналтын хуудсыг эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагаанд дотоодын болон хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийхэд ашиглах бөгөөд халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мөрдөгдөж байгаа журам, заавар, стандартын хэрэгжилтэд үнэлгээ өгөх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөхөд ашиглана.

Эрүүл мэндийн байгууллагад халдварын сэргийлэлт, хяналтын (ХСХ), эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас (ЭТҮХХ) сэргийлэх үйл ажиллагааг:

- Тасаг нэгжүүдээр явж хяналт хийх үед ашиглах харж үнэлэх;
- Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хийж байгаа үйл ажиллагааг баримт бичигт тулгуурлан үнэлгээ хийх;
- Эрүүл мэндийн ажилтаны дадал, хэвшил болгосон байх үйл ажиллагааг хянах гэсэн 3 чиглэлээр хяналт үнэлгээ хийнэ.

### НЭГ. ХАРЖ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ

#### 1.1. Гар угаах, халдваргүйжүүлэх

Үнэлгээ хийсэн огноо: .....

Үнэлгээнд хамрагдсан эмнэлэг, тасгийн нэр: .....

Шалгалт хийсэн хүний нэр: .....

Тийм, Үгүй гэсэн хариултаас нэгийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдэглэнэ.

№	Асуулт	Тийм	Үгүй	Тайлбар
1	Эмчилгээний өрөө бүрт гарын угаалтуур байгаа			
2	Үйлчлүүлэгчийн болон “00” өрөө бүрт гарын угаалтууртай			
3	Угаалтуурууд нь эвдрэл гэмтэлгүй хэвийн ажиллагаатай			
4	Эмчилгээний өрөөнүүдийн угаалтуур нь гар оролцохгүй ажиллах боломжтой			
5	Бүх угаалтуурын дэргэд шингэн саван байгаа			
6	Бүх угаалтуурын дэргэд зориулалтын			

	цаасан алчуур байгаа			
7	Олон дахин хэрэглэгдэх даавуун алчуур хэрэглэдэггүй			
8	Тусламж үйлчилгээний цэг бүрт гар халдваргүйжүүлэх бодис байгаа			
9	Гар халдваргүйжүүлэгч бодис нь хлоргексидин болон спирт агуулсан			
10	Гар халдваргүйжүүлэх бодис нь тунлагч бүхий зориулалтын савтай			
11	Гар халдваргүйжүүлэх бодисын сав нь цэвэрхэн			
12	Гар угаах ус нь нүдээр харахад цэвэр (төвлөрсөн усан хангамжийнх, зөөврийн бол ус нөөцлөх сав, угаагуур цэвэр байх)			
13	Эмнэлзүйн тасгийн эмч мэргэжилтнүүд нь бөгж, бугуйвч, бугуйн цаг зэрэг гоёл чимэглэлийн зүйлүүд зүүсэн			
14	Угаалтуур нь цэвэрхэн, угаалтуур дотор ямар нэгэн багаж хэрэгсэл байхгүй			
15	Гарын эрүүл ахуйг сахих, гар угаах аргачлалыг харуулсан санамж, зурагт хуудас гар угаалтуурын дэргэд байдаг			

Үнэлгээ:

“Тийм” гэж хариулсан үнэлгээ бүрт 1 оноо өгнө.

1, 5, 9, 14 дүгээр асуумжуудын аль нэгэнд нь “Үгүй” гэж хариулсан болон нийлбэр дүнгээр 5-аас дээш асуултад “Үгүй” гэж хариулсан бол гар угаах, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг **“Хангалтгүй”** гэж үнэлнэ.

Нийлбэр дүнгээр 3-4 асуултад “Үгүй” гэж хариулсан бол гар угаах, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг **“Дундаж”**, 2-оос бага асуултад “Үгүй” гэж хариулсан бол **“Хангалттай”** гэж үнэлнэ.

“Үгүй” гэсэн хариулт авсан үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

## 1.2. Хог хаягдлын менежмент

Үнэлгээ хийсэн огноо: .....

Үнэлгээнд хамрагдсан эмнэлэг, тасгийн нэр: .....

Шалгалт хийсэн хүний нэр: .....

“Тийм”, “Үгүй” гэсэн хариултаас нэгийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдэглэнэ.

№	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
<b>А. Хог хаягдал хариуцсан ажилтаны хөдөлмөр хамгааллын хувцас</b>				
1	Ажлын хувцастай (хөвөн даавуун хүрэм, өмд)			
2	Нүдний шил эсвэл нүүрний халхавчтай			
3	Малгайтай			
4	Зүү нэвтэрдэггүй бээлийтэй			
5	Хамгаалалтын гуталтай			
6	Хулдаасан хормогчтой			
7	Амны хаалттай			
<b>Б. Хог хаягдал түр хадгалах байр</b>				
8	Гадна талдаа хаяг, таних тэмдэгтэй			
9	Битүүмжлэл сайтай, цоожтой			
10	Гадагш гарсан хаалгатай			
11	Хана шал тааз нь угааж цэвэрлэх боломжтой			
12	Агааржуулалттай			
13	Гэрэлтүүлэг сайтай			
14	Усны шугамд холбогдсон, угаалтууртай			
15	Устгалын төвлөрсөн байгууламжгүй газарт халдваргүйжүүлэх автоклавтай			
16	Тусдаа цэвэрлэгээний хэрэгсэлтэй			
17	Ил задгай хог хаягдалгүй цэвэрхэн байх			
18	Хог хаягдал ангилан хадгалах сав хүрэлцээтэй			
19	Хог хаягдал жигнэх жинтэй			
20	Хог хаягдал цуглуулах тэргэнцэр эсвэл таг, бариултай савтай			
<b>В. Хог хаягдал цуглуулах уут, сав, зөөвөрлөх тэргэнцэрт тавигдах шаардлага</b>				
21	Хогийн уут нь амархан цоорч гэмтэхгүй зузаан (5 микроноос багагүй), шингэн нэвчээгүй			
22	Био аюулгүйн тэмдэгтэй			

23	Хогийн сав нь хөлөөр дарж онгойдог			
24	Гадна талд био аюулгүйн тэмдэгтэй			
25	Тэргэнцэр нь уутыг гэмтээхээр хурц ирмэг, үзүүргүй			
26	Тэргэнцэр нь хэрэглэхэд хялбар, цэвэрлэх боломжтой			

#### Г. Хог хаягдлыг ангилаж, цуглуулсан байдал

27	Хогийн сав бүр ууттай			
28	Хог хаягдал үүсч байгаа цэг бүрт хог хаягдлыг ангилж хийх уут, сав байгаа			
29	Цуглуулах уут, савны багтаамж нь үүсч байгаа хог хаягдлын хэмжээнд тохирсон			
30	Ажлын байранд хог хаягдлыг зөв ангилан ялгах талаар заавар санамж анхааруулга байрлуулсан			
31	Хогийн сав дүүрч асгараагүй (2/3-ээс дээш дүүргээгүй)			
32	Ахуйн хог хаягдал цуглуулсан саванд эмнэлгийн гаралтай тусгай хог хаягдал байхгүй			
33	Шар уутанд зүү, ампул гэх мэт иртэй, үзүүртэй хог хаягдал, эсвэл ахуйн хаягдлыг хийгээгүй			
34	Аюулгүй хайрцагт зүү, тариур, ампулаас бусад хог хаягдлыг (хөвөн, шарик, зүүний таглаа, зүүг таглаж хийх) хийгээгүй			
35	Хэрэглэсэн зүү, тариур, бээлий, цустай хөвөн зэрэг эмнэлгийн гаралтай тусгай хог хаягдлыг ил задгай орхиогүй			
36	Аюулгүй хайрцагтай хог хаягдлын зүү, шингэн нэвчээгүй, наалт задраагүй, зөв угсарсан			
37	Аюулгүй хайрцгийг 2/3-с хэтрүүлэн дүүргээгүй, нээсэн огноо, тасгийн нэрийг тэмдэглэсэн			
38	Эмчлүүлэгчийн өрөөнд тариа хийх үед тэргэнцэрт аюулгүй хайрцаг байрлуулсан			
39	Аюулгүй хайрцгийг суллаж дахин хэрэглэдэггүй			
40	Зориулалтын бус аюулгүй хайрцаг хэрэглэдэггүй			

#### Д. Хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх, устгах, халдваргүйжүүлэх

41	Хог хаягдлыг түр хадгалах байр руу зөөвөрлөхдөө маршрутыг мөрддөг			
42	Битүү саваар болон тэргэнцэрээр зөөвөрлөдөг			

43	Эмнэлэг дотор зөөвөрлөх цагийн хуваарийг баримталдаг			
44	Хог хаягдлыг 7 хоногт 2-3 удаа устгадаг			
45	Шингэн хог хаягдлыг халдваргүйжүүлж устгадаг			
46	Автоклавдаж халдваргүйжүүлдэг			
<b>Е. Ихсийн нүхэнд тавигдах шаардлага (орон нутагт)</b>				
47	Эмнэлгийн хашаанд, эмнэлгийн байрнаас 5-15м зайтай, ноёлох салхины доор байрласан байх			
48	Ихсийн нүх нь эрүүл ахуйн шаардлагын дагуу баригдсан (доороо хайргатай, хажуу ханыг цементлэсэн гэх мэт)			
49	Битүүмжлэл алдагдаагүй, гадагш нээгддэг төмөр тагтай, таг нь хаалттай			
50	Гадна тал нь цэвэр, цус, биологийн шингэнээр бохирлогдоогүй			
51	Үнэргүй, ялаа шумуул, мэрэгч амьтан үүрлээгүй			

Үнэлгээ:

“Тийм” гэж хариулсан үнэлгээ бүрт 1 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 14-аас дээш асуултад “Үгүй” гэж хариулсан бол хог хаягдлын менежмент **“Хангалтгүй”** гэж үнэлнэ.

Нийлбэр дүнгээр 8-13 асуултад “Үгүй” гэж хариулсан бол **“Дундаж”**, 7-оос бага асуултад “Үгүй” гэж хариулсан бол **“Хангалттай”** гэж үнэлнэ.

“Үгүй” гэсэн хариулт авсан үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

**1.3. Эмнэлгийн ажилтан зүүнд хатгуулах, хурц үзүүртэй, иртэй багажинд зүсэгдэх, халдварлагдсан биологийн шингэн ам, хамар, нүдний салстад үсрэх зэрэг эрсдлээс сэргийлэх**

Үнэлгээ хийсэн огноо: .....

Үнэлгээнд хамрагдсан эмнэлэг, тасгийн нэр: .....

Шалгалт хийсэн хүний нэр: .....

Тийм, Үгүй гэсэн хариултаас нэгийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдэглэнэ.

№	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Зүүг буцааж таглаагүй, хэрэглэсэн зүү тариурыг шууд аюулгүй хайрцагт хийдэг			
2	Аюулгүй хайрцаг нь зүү нэвтрээгүй, шингэн нэвчээгүй			
3	Шингэн үсрэх эрсдэлтэй ажилбар гүйцэтгэх үед ам, хамар, нүдний салстыг хамгаалж амны хаалт, нүдний шил болон нүүрний халхавч өмссөн			
4	Цус биологийн шингэнээр бохирдох эрсдэлтэй ажилбар гүйцэтгэхэд бээлий өмсөх			
5	Тасаг нэгжийн ажилтан урдуураа битүү гутал өмсдөг			
6	Тасаг нэгжид нэг удаагийн үзлэгийн бээлий хүрэлцээтэй			
7	Амны хаалт хүрэлцээтэй			
8	Нүдний шил болон нүүрний халхавч эмнэлгийн ажилтаны тоогоор (Ялангуяа шүдний кабинет, мэс засал, төрөх, дуран гэх мэт тасагт)			
9	Үйлчилгээний ажилтан ахуйн бээлий өмсөж цэвэрлэгээ хийдэг			
10	Тусламж үйлчилгээний цэг бүрт өртөлтийн дараах сэргийлэлтийн цомогтой			
11	Цомогт цус тогтоох болон шархны наалт, ариун боолт хийх хэрэгсэлтэй			
12	Цомогт зайлшгүй шаардлагатай антибиотиктой (Бензатинпенициллин G 2.4 сая, цефиксим 400 мг)			
13	Эмнэлэг, тасаг нэгжүүдэд ретровирусын эсрэг эмтэй			

Үнэлгээ:

“Тийм” гэж хариулсан үнэлгээ бүрт 1 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 4-аас дээш асуултад “Үгүй” гэж хариулсан бол эрүүл мэндийн ажилтаныг халдвараас сэргийлэх үйл ажиллагаа **“Хангалтгүй”** гэж үнэлнэ.

Нийлбэр дүнгээр 3 асуултад “Үгүй” гэж хариулсан бол **“Дундаж”**, 2-оос бага асуултад “Үгүй” гэж хариулсан бол **“Хангалттай”** гэж үнэлнэ.

“Үгүй” гэсэн хариулт авсан үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

**1.4. Ариутгалын тасаг, нэгжийн зохион байгуулалт, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал**

Үнэлгээ хийсэн огноо: .....

Үнэлгээнд хамрагдсан эмнэлэг, тасгийн нэр: .....

Шалгалт хийсэн хүний нэр: .....

Тийм, Үгүй гэсэн хариултаас нэгийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдэглэнэ.

№	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
<b>А.Барилга, байгууламж, өрөө тасалгааны зохион байгуулалт</b>				
1	Ариутгалын тасаг, хэсгийн урсгал зөв зохион байгуулагдсан			
2	Ариун, цэвэр, бохир хэсэг нь бүрэн тусгаарлагдсан			
3	Шал нь зориулалтын зузаан резинен хулдаастай			
4	Хана нь шаазан хавтан эсвэл тосон будаг, тааз эмульсдсэн			
5	Шал, хана, таазны будаг нь хуураагүй, хулдаас нь урагдаж цоороогүй			
6	Агааржуулалтын нэгдсэн системтэй, хэвийн ажиллагаатай, хэсгийн агааржуулалтын системтэй бол агаар сорох, татах системтэй			
7	Төвлөрсөн усан хангамжид холбогдсон халуун, хүйтэн устай, зөөврийн усан хангамжтай бол ус халаах, нөөцлөх, бохир ус зайлуулах боломж бүрдүүлсэн			
8	Багаж хүлээн авах, угаах, халдваргүйжүүлэх өрөөтэй			
9	Цэвэр багаж боох, савлах өрөөтэй			
10	Даавуун болон ороох боох материал бэлтгэх өрөөтэй			
11	Ариун материал хадгалах өрөөтэй			
12	Ажилтны хувцас солих, амрах өрөөтэй			
13	Багаж материал, бодис хадгалах нөөцийн өрөөтэй			x
<b>Б.Багаж, тоног төхөөрөмж, аюулгүй байдал</b>				
14	Багаж, хэрэгсэл угаах угаалгын автомат машинтай, гараар угаадаг бол зориулалтын зөөлөвчтэй угаалтууртай			
15	Багаж угаах зориулалтын зөөлөн үстэй ёрш, сойзтой			
16	Ус шүүгчтэй			
17	Ус нэрэгчтэй			
18	Хатаах шүүгээтэй, арчиж, өрөөнд тавьж хатаадаг бол тавиуртай			

19	Хуурай халууны шүүгээтэй			
20	Хэт авиан цэвэрлэгчтэй			
21	Уурын автоклавтай			
22	Автоклав нь ариутгалын үйл ажиллагаанд ачаалалгүй хүрэлцдэг			
23	Дуран угаах, халдваргүйжүүлэх автомат машинтай			x
24	Хийн плазмын ариутгагчтай			x
25	Пакетлагч машинтай			
26	Пакетлах уут, зориулалтын боолтын цаастай			
26	Хэрэглэх байдлаар багцалж зориулалтын боолтоор боодог эсвэл 2 давхар даавуун боолтонд боодог			
27	Багцлахгүйгээр биксэнд хийж ариутгадаггүй			
28	Томруулдаг шилтэй			
29	Багаж тослогч тос, зэв арилгагчтай			
30	Бохирлогдсон багаж, хэрэгслийг ариутгалын тасаг руу шууд зөөвөрлөж байгаа			
31	Зориулалтын зөөврийн сав байгаа			
32	Багаж материал хийх бикс бүрэн хаагддаг, түгжээтэй			
33	Биксийг 7 хоногт 1 удаа бүрэн цэвэрлэдэг			
34	Багаж цэвэрлэх бодистой			
35	Багаж халдваргүйжүүлэх бодистой			
36	Химийн аргаар ариутгах бодистой			
<b>В. Хяналт</b>				
37	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай			
38	Тоног төхөөрөмж ажиллах бүрт техникийн /физикийн/ хяналт хийдэг			
39	Автоклав ажиллах бүрт химийн хяналтын 2 төрлийн тестийг тавьдаг (боолттой багаж хэрэгслийн дотор болон гадна талд)			
40	Химийн хяналтын тестийн өнгө зохих түвшинд хувираагүй тохиолдол гараагүй			
41	Биологийн тестийг улиралд 1-ээс доошгүй удаа бүх автоклавт тавьдаг			
42	Бүх автоклавын уурын тархалтыг сард 1-ээс доошгүй удаа хянадаг			
<b>Г. Хүний нөөц, чадавхи</b>				
43	Бүс бүрт ажиллах хүний нөөцтэй /хүний тоо/			x
44	Бүх ажилтнууд нь ариутгалын ажилтаны мэргэжил олгох сургалтад хамрагдсан			
45	Хувийн хамгаалах хувцас, хэрэглэлээр хангагдсан (доорх хэрэгслээс нэг дутуу бол асуултыг үгүй гэж бөглөнө)			

	Үүнд	Малгай			
		Хормогч			
		Нөмрөг			
		Бээлий			
		Амны хаалт			
		Нүүрний хамгаалалт			
		Нүдний шил			
		Ажлын /усны / гутал			
46	Өртөлтийг бүртгэдэг, өртөлтөөс сэргийлэх иж бүрдэлтэй				
47	Анхны тусламж үзүүлэх эмийн сантай				
<b>Д. Халдваргүйжүүлэх бодист тавигдах шаардлага, хангамж, хэрэглээ</b>					
48	Халдваргүйжүүлэлтэд хэрэглэж байгаа бодисууд нь улсын бүртгэлд бүртгэгдсэн				
49	Хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны заавар байгаа				
50	Халдваргүйжүүлэх бодисыг зориулалтын дагуу хэрэглэж байгаа				
51	Найруулах, хэрэглэх аргыг мөрдөж байгаа				
52	Халдваргүйжүүлэх уусмалын хугацаа хүчинтэй				
53	Ажлын уусмалын найруулсан огноог тэмдэглэсэн				
54	Халдваргүйжүүлэх бодисын нэр, хувийг тэмдэглэсэн				
55	Халдваргүйжүүлэх уусмал хэмжигч, дозатор байгаа				
56	Халдваргүйжүүлэх уусмал найруулсан сав нь цэвэр, тагтай				
57	Бодисыг зөв хадгалсан				
58	Багажны цэвэрлэгээнд зориулалтын бодис хэрэглэдэг				
59	Багажны халдваргүйжүүлэлтэд зориулалтын бодис хэрэглэдэг				
60	Халдваргүйжүүлэх бодисын үлдэгдлийг хангалттай саармагжуулж байгаа				

Тайлбар хэсэгт Х тэмдэглэсэн асуултыг ариутгалын хэсэг ажилладаг сум, өрхийн ЭМТ-д үнэлэхгүй байж болно. Үнэлгээ өгөхдөө үнэлгээний нийт асуумжаас хасна.

Үнэлгээ:

“Тийм” гэж хариулсан үнэлгээ бүрт 1 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 18-аас дээш асуултад “Үгүй” гэж хариулсан, эсвэл 70% -иас бага оноо авсан бол ариутгалын үйл ажиллагаа **“Хангалтгүй”** гэж үнэлнэ.

Нийлбэр дүнгээр 9-17 асуултад “Үгүй” гэж хариулсан, эсвэл 71% -85% байгаа бол **“Дундаж”**, 8-аас бага асуултад “Үгүй” гэж хариулсан, 86% -иас дээш оноо авсан бол **“Хангалттай”** гэж үнэлнэ.

“Үгүй” гэсэн хариулт авсан үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

### 1.5. Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ

Үнэлгээ хийсэн огноо: .....

Үнэлгээнд хамрагдсан эмнэлэг, тасгийн нэр: .....

Шалгалт хийсэн хүний нэр: .....

№	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
<b>А. Цэвэрлэгээ, цэвэрлэгээний бодист тавигдах шаардлага, хангамж</b>				
1	Эмнэлгийн орчныг А, В, С бүсээр ангилсан			
2	Тасаг нэгж бүр цэвэрлэгээний тэргэнцэртэй			
3	Цэвэрлэгээний тэргэнцэр нь тоос шороогүй, асгарсан шингэнгүй			
4	Тэргэнцэрт цэвэрлэгээнд хэрэглэх зүйлс бүрэн байх. (Доорх хэрэгслээс нэг нь байхгүй бол энэ асуумжийн үнэлгээг үгүй гэж үнэлнэ) Үүнд			
	Халдваргүйжүүлэх бодис			
	Угаалгын нунтаг, саван			
	Шалны алчуур			
	Тоос, шал арчих уусмал тусдаа савтай			
	Алчуур			
	Ахуйн бээлий			
	Хальтаргаанаас анхааруулах тэмдэг			
5	Цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэл, хяналтын хуудас байгаа			
6	Цэвэрлэгээ хийх хуваарьтай байгаа			
7	Цэвэрлэгээний материал хангалттай			
8	Халдваргүйжүүлэх бодисыг зориулалтын дагуу хэрэглэж байгаа			
9	Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнийг халдваргүйжүүлэн цэвэрлэх цомог, иж бүрдэлтэй			
10	Цэвэрлэгээ хийх үедээ ахуйн бээлий, хамгаалах хувцас өмсдөг			
<b>Б. Цэвэрлэгээний чанар</b>				
11	Хонгилын шат, галын гарц, шат, үүдэвч, тоос шороогүй, аалзны тор, тамхины иш, шувууны сангас, шаралсан навч унаагүй хог хаягдалгүй байх			
12	Хана, таазны дотор тал нь тоосгүй, толбогүй бохирдолгүй			
13	Хана, таазны бэхэлгээ, тоноглолууд (унтраалга, залгуур) тоос, бохирдолгүй			
14	Гэрлийн бүрхүүл нь тоосгүй, цэвэр			
15	Шилний гадаргуу, хүрээ, тавцан нь хурууны мөр болон бусад бохир, халтар толбогүй цэвэрхэн			

16	Хаалганы дотор болон гадна тал, хаалганы хүрээ нь тоос шороогүй, бохирдолгүй цэвэрлэгдсэн			
17	Шал, шалны хүрээ, булан тохой нь тоос шороогүй, бохир толбогүй, цаас болон хог хаягдалгүй, ус болон шингэн асгараагүй			
18	Цэвэрлэсэн нойтон шалан дээр явган хүн болгоомжтой явах талаар тэмдэглэгээ тавьдаг			
19	Агааржуулах нүх, агааржуулалтын хэсэг нь тоос шороогүй, ямар нэгэн өнгөр тогтоогүй			
<b>В.Тавилга, хэрэгслийн цэвэрлэгээ</b>				
20	Цахилгаан хэрэгсэл нь тоос шороогүй, ямар нэг толбо, өнгөргүй			
21	Тавилга, тавиур, ширээ, сандал, хувцасны шүүгээний гадаргуу нь тоос шороогүй			
22	Тавилгын хөл, дугуйн хөлнүүд, тавилгын булан тохой, хүрээ, завсар нь бохир толбогүй, тоос шороогүй			
23	Шаазан болон хуванцар гадаргуутай суултуур бүрэн, гэмтэлгүй, зэв үүсээгүй, бохир ямар нэг толбогүй, өнгөргүй, бохирлогдоогүй			
24	Ариун цэврийн өрөөний ханан дахь тавцангууд нь мөөгөнцөртөөгүй, тоосгүй цэвэр			
25	Ус дамжуулах хоолойнууд нь тоосгүй ямар нэг толбо үүсээгүй			
26	Ариун цэврийн өрөөний хог хаягдлын сав нь хөл ажиллагаатай, тагтай, гэмтэл, хагаралгүй, цэвэрлэгдсэн			
27	Тоног төхөөрөмжийн гадаргуу нь цэвэр, ямар нэг бохир толбогүй			
28	Угаалтуур цэвэр			

Үнэлгээ:

Тийм гэж хариулсан үнэлгээ бүрт 1 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 6 –аас дээш асуултанд “Үгүй” гэж хариулсан бол цэвэрлэгээ “Хангалтгүй” гэж үнэлнэ. Цэвэрлэгээг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

Нийлбэр дүнгээр 4-өөс бага асуултанд “Үгүй” гэж хариулсан бол “Хангалттай” гэж үнэлнэ.

## ХОЁР. БИЧИГ БАРИМТЫН ҮНЭЛГЭЭ

### 2.1. Гар угаах, халдваргүйжүүлэх

№	Асуултууд	Тийм	Үгүй	Гүйцэт бус	Тайлбар
1	Гарын ариун цэвэр сахилтын ажиглалтын судалгааг улирал бүр хийж үнэлдэг				
2	Гарын ариун цэвэр сахилтын ажиглалтын судалгааны төгсгөлд үр дүнг эмч, ажилтанд мэдээлдэг				
3	Үнэлгээний дүнг үндэслэн эмнэлгийн ажилтныг гарын ариун цэвэр сахилтыг сайжруулах талаар ажил зохион байгуулсан				
4	Гарын ариун цэврийн талаар жилд 2-оос доошгүй эмнэлгийн ажилтанд сургалт хийдэг эсэх				
5	Сургалтад эмнэлгийн ажилтныг бүрэн хамруулдаг				
6	Шинээр орсон ажилтанд гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг олгох сургалт, дадлага хийлгэдэг				
7	Эмнэлгийн ажилтныг гар угаах, халдваргүйжүүлэх сургалтад хамруулах талаар байгууллагад мөрдөж байгаа журамд тусгасан				
8	Гар угаах, халдваргүйжүүлэх сургалт хийх сургалтын хэрэгсэл байгаа (хичээл, дадлагад хэрэглэх хэрэгсэл, үр дүнг үнэлэх хэрэгсэл гэх мэт)				
9	Гар халдваргүйжүүлэх бодис, саван, нэг удаагийн алчуурын хэрэглээг тооцдог				
10	Гар халдваргүйжүүлэх бодис, саван, нэг удаагийн алчуурын хангалт, хүрэлцээний байдалд үнэлгээ хийдэг				
11	Өдөрт зарцуулагдаж буй гар халдваргүйжүүлэх бодисын хэмжээг тооцож гаргадаг				
12	Жилд 1-ээс доошгүй удаа эмнэлгийн ажилтнуудын гар угаах, халдваргүйжүүлэх зөв техникийг үнэлдэг				
13	Жилд 1-ээс доошгүй удаа эмнэлгийн ажилтнуудын гарын ариун цэврийн талаар мэдлэгийн түвшинг үнэлдэг				

Үнэлгээ:

Тийм гэж хариулсан үнэлгээ бүрт 1, гүйцэт бус бол 0,5 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 8 –аас доош оноо авсан бол “Хангалтгүй” гэж үнэлнэ. Гарын эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Нийлбэр дүнгээр 8,1 -өөс дээш оноо авсан бол “Хангалттай” гэж үнэлнэ.

## 2. 2. Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэнд, дархлаажуулалт

№	Асуултууд	Тийм	Үгүй	Гүйцэт бус	Тайлбар
1	ЭМА-д халдвараас сэргийлэх, зааврыг танилцуулдаг				
2	ЭМА-д халдвараас сэргийлэх чиглэлээр сургалт хийх хөтөлбөр, төлөвлөгөөтэй				
3	Сургалтыг жилд 2-оос доошгүй удаа хийсэн				
4	Шинээр ажилд орж байгаа хүмүүст эрсдэлт хүчин зүйлийн талаар зөвлөгөө санамж өгдөг				
5	Халдвараас сэргийлэх сургалт хийх арга хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй				
6	ЭМА-ыг хариуцсан эмчтэй				
7	ЭМА-ыг жилд 1-ээс доошгүй удаа төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан				
8	Шинээр ажилд орж байгаа иргэдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан				
9	ЭМА-д цусаар дамжих халдварын илрүүлэг шинжилгээг жил бүр хийдэг (HBsAg, HCV, HDV, HIV)				
10	В вируст гепатитын вакцинд хамрагдвал зохих эмнэлгийн ажилтаныг 3 тун вакцинд 100 хувь хамруулсан				
11	Эмнэлгийн ажилтаны гепатитын В вируст гепатитын эсрэг вакцинд хамрагдалтын бүртгэл судалгааг нэгтгэн гаргасан				
12	В вируст гепатитын вакцинд хамрагдсан ажилтануудыг дархлал тогтоцын шинжилгээнд (HBs эсрэг бие) хамруулсан				
13	Улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдсан болон өвдсөн эмнэлгийн ажилтаны судалгааг гаргасан				
14	Улаанбурхан өвчний эсрэг вакцинд хамрагдвал зохих эмнэлгийн ажилтаныг вакцинд 100 хувь хамруулсан				
15	Шинэ ажилтан авахдаа улаанбурхан, В вируст гепатитын эсрэг вакцины хамрагдалт, дархлаажуулалтын мэдээллийг авдаг				
16	Жил бүр томуугийн эсрэг вакцинд хамруулдаг				

17	ЭМА-ы халдвар авах эрсдэлт хүчин зүйлийг бүртгэдэг				
18	Өртөлтийн дараа халдвар авах эрсдлийн үнэлгээ хийж сэргийлэх арга хэмжээг авдаг, тэмдэглэсэн				
19	Өртөлтийн мэдээллийг сар бүр гаргаж дараагийн шатны ЭМБ-д мэдээлсэн				
20	Өдөр тутмын тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хамгаалах хувцас хэрэгслээр (бээлий, нүдний шил, нүүрний халхавч, амны хаалт, халад гэх мэт) тасралтгүй хангадаг, хүрэлцээтэй, нөөцтэй				
21	Халдварлах эрсдэл өндөртэй халдварт өвчний үед хэрэглэх иж бүрэн хамгаалах хувцас хэрэгслийг өмсөж, тайлах дадалд эмч, мэргэжилтнүүдийг сургасан				
22	Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй, бэлэн байдлыг хангасан (Доод хэсгийн нэгдсэн дүнгээр үнэлгээ өгнө) Үүнд:				
Тоогоор	Шүүлтүүртэй амны хаалт				
	Мэс заслын амны хаалт				
	Малгай, юүдэн				
	Халад				
	Хормогч				
	Нүдний шил, нүүрний хаалт				
	Комбинзон				
	Бээлий (ариун)				
	Бээлий /үзлэгийн/				
	Бээлий /ахуйн/				
	Усны гутал, гутлын гадуурх углааш				

Үнэлгээ:

Тийм гэж хариулсан үнэлгээ бүрт 1, гүйцэт бус бол 0,5 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 15,5 –аас доош оноо авсан бол “Хангалтгүй” гэж үнэлнэ. ЭМА-ын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах ажлыг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Нийлбэр дүнгээр 16 –ээс дээш оноо авсан бол “Хангалттай” гэж үнэлнэ.

### 2. 3. Хог хаягдлын менежмент

№	Асуултууд	Тийм	Үгүй	Гүйцэт бус	Тайлбар
1	Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөтэй, төлөвлөгөөг хэрэгжүүлдэг				
2	Эмнэлгээс гарч байгаа тусгай хог хаягдлын байдалд судалгаа хийж сар бүр нэгтгэсэн				
3	Тусгай хог хаягдлыг устгуулах гэрээтэй				
4	Хог хаягдлын менежментэд зарцуулагдах төсөв хүрэлцээтэй				
5	Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, устгах, аюулгүй болгоход шинэ дэвшилтэд хэрэгслийг хэрэглэж байгаа (өөрөө эвдэрдэг зүү, хуванцар аюулгүй хайрцаг, зүү бутлагч гэх мэт)				
6	Химийн, эмийн хог хаягдал цуглуулах уут савтай				
7	Хог хаягдлыг цуглуулах уут, савны нөөцтэй				
8	Хог хаягдлын ажилтанг томилсон				
9	Ажилтануудыг сургалтанд хамруулсан				
10	В вируст гепатитын эсрэг вакцины 3 тунд хамрагдсан				
11	Хог хаягдлын менежментийг сайжруулах сургалт зохион байгуулсан				
12	Зүү буцааж таглах, хог хаягдлын уут савыг суллах зэрэг буруу дадал байгаа эсэхэд судалгаа, үнэлгээ хийсэн				

Үнэлгээ:

Тийм гэж хариулсан үнэлгээ бүрт 1, гүйцэт бус бол 0,5 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 8,5 –аас доош оноо авсан бол “Хангалтгүй” гэж үнэлнэ. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Нийлбэр дүнгээр 9 -ээс дээш оноо авсан бол “Хангалттай” гэж үнэлнэ.

**2.4. Ариутгалын тасаг, нэгжийн зохион байгуулалт, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал**

№	Асуултууд	Тийм	Үгүй	Гүйцэт бус	Тайлбар
1	Ариутгалд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах санхүүжилт төсөвт тусгагдсан				
2	Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодис, хяналтын тестүүд, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах засвар үйлчилгээг тогтмол хийдэг, зардлыг шийдвэрлэсэн				
3	Ариутгалын тасагт бохирлогдсон багаж, хэрэгслийг тасаг нэгжээс хүлээн авсан, ариутгасны дараа хүлээлгэн өгсөн тэмдэглэл байгаа (нэр, тоогоор)				
4	Тасагт багаж хэрэгслийг хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан тэмдэглэл байгаа (нэр, тоогоор)				
5	Багаж хэрэгслийг цэвэрлэж, хатааж, халдваргүйжүүлсэн, ариутгасан тухай тэмдэглэл байгаа				
6	Автоклавын ажиллагааны хяналтын тестийн тэмдэглэгээ байгаа				
7	Автоклав болон бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тэмдэглэл байгаа				
8	Биологийн хяналтын тэмдэглэл байгаа				
9	Уурын тархалтыг зааврын дагуу хянадаг хяналт байгаа				
10	Техникийн /физикийн/ хяналтын тэмдэглэл байгаа				
11	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай				
12	Зааварчилгааг ажилтануудад танилцуулан баталгаажуулсан				
13	Ариутгалын ажилтанг сургалтад хамруулах төлөвлөгөөтэй				
14	Сургалтыг төлөвлөгөөний дагуу явуулдаг				

Үнэлгээ:

Тийм гэж хариулсан үнэлгээ бүрт 1, гүйцэт бус бол 0,5 оноо өгнө.

Нийлбэр дүнгээр 9,5 –аас доош оноо авсан бол “Хангалтгүй” гэж үнэлнэ. Ариутгалын үйл ажиллагааг шаардлагатай.

Нийлбэр дүнгээр 10 -аас дээш оноо авсан бол “Хангалттай” гэж үнэлнэ.

**ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАНЫ МЭДЛЭГ, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ**  
**3.1: Гар угаах, халдваргүйжүүлэх**

№	Асуултууд	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тайлбар
1	Гарын ариун цэвэр сахих 5 мөчийг нэрлэж чадаж байна уу				
2	Гарын ариун цэвэр сахиагүйгээс гарч болох эрсдлийн талаар мэдэж байна уу				
3	Зөв техникээр гараа угааж чадаж байна уу Дор хаяж 5-аас доошгүй ажилтанд шалгах				
3.1	Ханцуйг тохой хүртэл шамлана				
3.2	Гараа бүрэн норгосон уу				
3.3	Хүрэлцэхүйц хэмжээний саван авсан уу				
3.4	Гарын алга хооронд үрж угаасан уу				
3.5	Хоёр гарын ар талыг угаасан уу				
3.6	Гарын хурууны завсарыг угаасан уу				
3.7	Хоёр гарын хурууг үеэр нугалж алга дотроо үрж угаасан уу				
3.8	Эрхий хурууг алга дотроо үрж угаасан уу				
3.9	Алганы хонхор хэсгийг угаасан уу				
3.10	Хурууг алга дотроо үрж угаасан уу				
3.11	Бугуйн хэсгийг угаасан уу				
3.12	Гараа цэвэр усаар саванг арилтал зайлсан уу				
3.13	Гараа цаасан алчуураар арчсан уу				
3.14	Угаасан гараа крантад хүргэлгүйгээр усаа хаасан уу				
4	Зөв техникээр гараа халдваргүйжүүлж чадаж байна уу Дор хаяж 5-аас доошгүй ажилтанд шалгах				
4.1	Хүрэлцэхүйц хэмжээний бодис авсан уу				
4.2	Гарын алга хооронд үрсэн үү				
4.3	Хоёр гарын ар талыг үрж байна уу				
4.4	Гарын хурууны завсарыг үрсэн үү				
4.5	Хоёр гарын хурууг үеэр нугалж алга дотроо үрж байна уу				
4.6	Эрхий хурууг алга дотроо үрсэн үү				
4.7	Алганы хонхор хэсгийг үрж байна уу				
4.8	Бугуй хэсгийг үрж байна уу				
5	Гарын ариун цэвэр сахих 5 мөчийг мөрдөж байна уу				
5.1	Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө гараа угаах, эсвэл халдваргүйжүүлсэн үү				
5.2	Ариун ажилбар гүйцэтгэхийн өмнө				
5.3	Үйлчлүүлэгчид хүрсний дараа				
5.4	Биологийн шингэнтэй харьцсаны дараа				
5.5	Үйлчлүүлэгчийн орчны эд зүйлд хүрсний дараа				

### 3.2: Нэг удаагийн хамгаалах хувцас өмсөх, тайлах

№	Үйл ажиллагаа	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тайлбар
<b>А. Бээлий өмсөх ба тайлах</b>					
1	Гарын хэмжээнд тохирсон бээлийг сонгоно				
2	Гараа угаана				
3	Бээлийг өмсөхөөс өмнө бүрэн бүтэн эсэхийг шалгаж өмсөнө				
4	1 гарын бугуйны ойролцоох гадна талын ирмэгнээс чанга барьж дотроос нь гадагш эргүүлэн хуйлж тайлна				
5	Тайлсан бээлийг эсрэг талын бээлийтэй гараараа барина				
6	Бээлийгүй талын хуруугаа бээлийтэй гарынхаа бээлийний дотуур оруулна				
7	Дотроос нь хуйлж тайлна				
8	Бээлийгээ шар ууттай хогийн саванд хийнэ				
9	Гараа угаана				
<b>Б. Шүүлтүүртэй амны хаалт (N- 95 амны хаалт) зүүх</b>					
1	Алганы хонхорхойд амны хаалтны аяга хэсгийг, хамрын хэсэг нь хуруунуудын үзүүрт, толгойн уяа нь гарт сул унжиж байхаар гарт байрлуулан барина				
2	Бүч болон амны хаалтны бүтэн эсэхийг нягтална				
3	Эрүүний доод хэсгээс хамрын дээд хэсэг хүрэхээр тохируулан барина				
4	Доод уяаг нь чангалж татаад чихний доод хэсэгт хүзүүний орчимд, дээд талын уяаг нь толгойны ар талд дээд хэсэгт хөдөлгөөнгүй тогтооно				
5	Хоёр гарынхаа хурууны үзүүрүүдээр хамрын хэсэгт байгаа металл дээр дарж хамрынхаа хэлбэрт тохируулна. Нэг гараараа хамрын дээд хэсгээс чимхэж үр дүнтэй болсон эсэхийг шалгана				
6	Толгойг бага зэрэг бөхийлгөн толгойн ар талаас доод талын резиныг дээш өргөн, дээд талын резинтэй хамт дээш өргөн тайлна				
<b>В. Нүдний шил өмсөх, тайлах</b>					
1	Нүдний шилний бүрэн бүтэн байдлыг шалгана				
2	Нүдний шилний доод талыг нүдний ухархайн доод хэсэгт, дээд талыг				

	хөмсөг дээгүүр байрлуулан уяаг толгойн ард татаж байрлуулна			
3	Толгойг бага зэрэг бөхийлгөн толгойн ард хэсгийн уяанаас татаж суллан тайлна			

**Г. Нэг удаагийн хэрэглээний хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх ба тайлах**


**Өмсөх**

1	Бээлий өмсөнө			
2	Комбинзон өмсөнө			
3	Усны гутал өмсөж, комбинзоны шуумгийг гутлын түрийний гадуур гаргана			
4	Амны хаалт зүүнэ			
5	Нүдний шил зүүнэ			
6	Комбинзоны малгайг өмсөж цахилгааныг гүйцэд татна			
7	Бээлийг бүтэн эсэхийг шалгасаны дараа өмсөнө			
8	Комбинзоны гадуур халад өмсөнө			
9	Давхар бээлийг халадны ханцуйг даруулж өмсөнө			

**Тайлах**

1	Халдваргүйжүүлэх бодис бүхий уусмалтай саванд гишгэж гутлын улыг халдваргүйжүүлсэний дараа уусмал шингээсэн алчуур дээр зогсоно			
2	Бээлийтэй гарыг угаана			
3	Гадуур бээлийг тайлна			
4	Бээлийтэй гарыг угаана			
5	Хормогчийн бүчийг зөөлөн татаж таслан дотрыг гадагш эргүүлэн тайлна			
6	Бээлийтэй гарыг угаана			
7	Комбинзоны цахилгааныг зөөлөн татаж, малгайн гадна хэсгээс арагш татан комбинзоны дотор талыг гадагш эргүүлэн тайлна			
8	Бээлийтэй гарыг угаана			
9	Бээлийг тайлна			
10	Гарыг угаана			
11	Шинэ бээлий өмсөнө			
12	Нүдний шилийг тайлна			
13	Бээлийтэй гарыг угаана			
14	Амны хаалтыг тайлна			
15	Бээлийтэй гарыг угаана			
16	Бээлийг тайлна			
17	Гарыг угаана			
18	Гутлыг тайлна			
19	Гарыг халдваргүйжүүлнэ			

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 04 сарын 27-ны өдрийн  
А. дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт



**Эмнэлгийн тархвар судлаачийн ажлын байрны тодорхойлолтын загвар**

Байгууллагын нэр		Нэгжийн нэр	
Бүх шатны эмнэлэг		Тасаг, нэгж	
Ажлын байрны нэр		Ангилал	Зэрэглэл
Эмнэлгийн тархвар судлаач		Засгийн газрын тогтоолд зааснаар	
Шууд харъяалагдах ажлын байр (албан тушаал)		Шууд харъяалах албан тушаал	
Эмнэлгийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга		Тасаг нэгжийн халдвар хяналтын ажилтан, Тасгийн эрхлэгчид болон эмч, сувилагчид Хог хаягдлын ажилтан Хоол үйлдвэрлэлийн ажилтнууд	
Ажлын байрны зорилго	Тухайн эрүүл мэндийн байгууллагад ЭТҮХХ гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх, халдвараас сэргийлэх арга хэмжээнд хяналт тавих, ЭТҮХХ, халдварт өвчин гарсан тохиолдолд хариу арга хэмжээг авах, тандалт судалгаа хийх, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох		
Ажлын байрны үндсэн зорилт	<ol style="list-style-type: none"> <li>1. Халдварын сэргийлэлт хяналт</li> <li>2. Тандалт, судалгаа</li> <li>3. Эрсдэлийн үнэлгээ/Өвчтөний аюулгүй байдал</li> <li>4. Нян судлалын лабораторитай нягт хамтын ажиллагаа</li> <li>5. Эм зүйн тасагтай нягт хамтын ажиллагаа</li> <li>6. Тоног төхөөрөмжийн стандарт, засвар үйлчилгээнд тавих хяналт /энэ нь тоног төхөөрөмжийн инженерийн асуудал бөгөөд арай өөрөөр ХСХ тал руу томьёолох/</li> <li>7. Хариу арга хэмжээг шуурхай авах төлөвлөгөө</li> <li>8. Эмнэлгийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хүнсний аюулгүй байдалд тавих хяналт</li> </ol>		

**“Б” Ажлын байрны гол үйл ажиллагаа**

Ажлын байрны гол үйл ажиллагаа	Хугацаа
<p><u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Халдварын хяналт, сэргийлэлтийн үндсэн шаардлагуудын мөрдөлтөнд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр удирдах</li> <li>- Байгууллагын хэмжээнд халдварын сэргийлэлт хяналт, эрүүл ахуйн чиглэлээр сургалтыг тасралтгүй зохион байгуулах, зөвлөмж, гарын авлага материалаар хангах</li> <li>- Халдварын дэгдэлтийн байдалд судалгаа хийх, дүгнэлт гаргах, хариу арга хэмжээ төлөвлөн зохион байгуулах</li> <li>- Халдвар хяналтын ажилтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах</li> <li>- ХСХ стратегийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх</li> <li>- Эмнэлгийн тулгамдсан асуудал болон эрсдэл өндөр тасаг,</li> </ul>	

<p>нэгжийг тогтоох, шийдвэрлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Халдварын сэргийлэлт хяналтын өртөг багатай, үр дүн сайтай аргыг эрэлхийлэх нэвтрүүлэх, байгаа болон шаардлагатай нөөцийг тогтоох</li> <li>- ХСХ-д шаардлагатай төсөв, хэрэгслийн тооцоог гаргах, нөөцийг тогтоох</li> </ul>	
<p><u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Идэвхигүй болон идэвхитэй тандалт хийх удирдамж, тушаалын заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах</li> <li>- ЭТҮХХ, халдварт болон халдварт бус өвчлөлийн байдалд тандалт, судалгаа хийж шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох</li> <li>- Дэгдэлтийн судалгаа хийх, дүгнэлт гаргах, таслан зогсоох арга хэмжээ авах</li> <li>- ЭТҮХХ-ын тохиолдол бүрт судалгаа хийх</li> <li>- ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээ авахад тухайн эрүүл мэндийн байгууллагын чадамж хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн туслалцаа авч ажиллах</li> </ul>	
<p><u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- ЭТҮХХ, халдварт өвчний дэгдэлт гарч болох эрсдэлт хүчин зүйлийг тогтоох</li> <li>- Эрсдэлийг үнэлэх, нотолгоонд тулгуурлан бууруулах арга хэмжээ авах</li> <li>- Эрсдэлтэй уялдуулан ХСХ-ын бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэнд хяналт тавих</li> </ul>	
<p><u>Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Халдварын түргэвчилсэн оношлогооны аргыг ашиглаж буй байдалд хяналт тавих</li> <li>- Нян судлалын лабораториос мэдээ, мэдээллийг шуурхай авах, хариу арга хэмжээг авч ажиллах</li> <li>- Нян судлалын лабораторийн шинжилгээний үр дүнд дүн шинжилгээ хийх</li> <li>- Нян судлалын лабораторитой хамтран сэрэмжлүүлэх нянгийн жагсаалтыг гаргах</li> <li>- Олон эмэнд тэсвэртэй, сэрэмжлүүлэх нян гарсан тохиолдолд эмнэлэгт халдвар тархаахгүй байх арга хэмжээг авах</li> <li>- Тохиолдолын болон өвчлөлийн түвшин тогтоох илрүүлэг шинжилгээний хариунд дүгнэлт хийх</li> <li>- Нянгийн эсрэг эмийн хэрэглээнд нян судлалын лабораторитой хамтран дүн шинжилгээ хийх</li> <li>- Лабораторийн био-аюулгүй ажиллагаанд хяналт тавих</li> </ul>	
<p><u>Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Антибиотик мэдрэг чанарын шинжилгээний дүнг эмчилгээнд ашиглаж байгаа байдлыг хянах</li> <li>- Антибиотикийн хэрэглээ, сонголтонд эмийн эмчилгээний хороотой хамтран хяналт тавих</li> <li>- Антибиотикт тэсвэртэй нян үүсэхээс сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх</li> <li>- Урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэж буй антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх</li> </ul>	

<p align="center"><u>Ажлын байрны VI үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тоног төхөөрөмж ялангуяа ариутгах, халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийн сонголтод оролцох, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих</li> <li>- Тоног төхөөрөмж суурилуулах, засвар үйлчилгээ хийх үед өвчтөнд халдвар үүсгэж болзошгүй /бичил биет-Legionella, Aspergillus/ эрсдэлийг тооцоолох, сэргийлэх арга хэмжээг төлөвлөх</li> <li>- Суурилуулалт, засвар үйлчилгээний үед үүсэх бохирдолын үед холбогдох цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгах, халдваргүйжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх</li> </ul>	
<p align="center"><u>Ажлын байрны VII үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн үеийн хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах</li> <li>- Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварын үед авах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах</li> <li>- Дэгдэлт, ЭТҮХХ, буюу халдварын үед авах арга хэмжээг төлөвлөх.</li> </ul>	
<p align="center"><u>Ажлын байрны VIII үндсэн зорилтын хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн хоолны үйлчилгээ, хоол тэжээл бэлтгэн нийлүүлэгчдийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдсан байдалд хяналт тавих, хамрагдах шаардлага тавих</li> <li>- Эмнэлгийн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд эрүүл ахуйн зохистой дадал мөрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах</li> <li>- Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих</li> <li>- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах журам, техникийн зохицуулалтанд хяналт тавих</li> </ul>	

**“B” Тавигдах шаардлага**

1. Ажлын байранд тавигдах шаардлага	Эмнэл зүйн ур чадвар	Үзүүлэлт	Зайлшгүй шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Нийгмийн эрүүл мэнд, Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
		Мэргэжил	Эрүүл ахуйч, тархвар судлаач эмч, нийгмийн эрүүл мэнд судлаач	
		Мэргэшил	Тархвар судлаачийн мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байх	Ахлах, тэргүүлэх зэрэгтэй байх
		Туршлага	Мэргэжлээрээ 3-с доошгүй жил ажилласан байх	
	᠑	Гадаад хэл	- Англи хэлний зохих мэдлэгтэй	Бусад хэлний дундаас

			доошгүй түвшний мэдлэгтэй
	Компьютерийн мэдлэг	- Хэрэглээний программ бүрэн ашиглах - Интернетийн орчин, дотоод сүлжээнд чөлөөтэй ажиллах	
	Судалгааны арга зүй	- Статистик судалгааны программуудыг ашиглах, дүн шинжилгээ хийх	
	Бусад ур чадвар	- Багаар ажиллах - Биеэ зөв боловсон авч явдаг байх - Харилцааны соёлтой байх - Хууль, эрх зүйн мэдлэгтэй байх - Удирдан зохион байгуулах, бодлого боловсруулах чадвартай байх - Өөрчлөлтийг манлайлах, бодлогыг хэрэгжүүлэх - ХСХ-ын ажилтантай хамтран ажиллах ур чадвартай, эмч нарын дунд нэр хүндтэй, итгэл хүлээхүйц - Эмнэлгийн удирдлагын итгэл даах - Тархвар судлалын чиглэлээр мэргэшсэн, мэдлэг сайтай, үр дүн муутай, өртөг өндөр үйл ажиллагааг илрүүлэх, өөрчлөх сэтгэлгээтэй - Эмнэлгийн тархвар судлал чиглэлээр сургалтанд хамрагдсан	
	1.2. Тусгай шаардлага	- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах - Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх	

### “Г” Хүчин зүйлс

1. Ажлын байрны харилцах субъект		
1.1. Байгууллагын дотор талд		1.2. Байгууллагын гадна талд
- Байгууллагын дарга/захирал		- Үйлчүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигч
- Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга		- төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлгийн эмч нар
- Тасаг/кабинетийн эрхлэгч, бусад их эмч, сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтан		- Тухайн мэргэжлийн чиглэл үйд ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн нийгэмлэг, холбоод
		- Төрийн болон төрийн бус бусад байгууллага
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Ажлын байрны үндсэн зорилтонд заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг байгууллагын дарга, захирлын өмнө хариуцна.	

3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1. Санхүүгийн:	- Үндсэн цалинг Засгийн газрын тогтоолын дагуу тооцож олгох - Хууль тогтоомжийн дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил олгох
	3.2. Материалын	- Ажлын байрны стандартыг хангасан өрөө, тавилга - Компьютер, дагалдах хэрэгслийн хамт - Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл - Дотуур холбоо, дотоод сүлжээ
	3.3. Хүний	- Тасаг/ кабинетийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, бусад ажилтантай хамтран ажиллах
	3.4. Бусад	- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр үнэ төлбөргүй хамрагдах
4. Ажлын байрны нөхцөл	Ердийн	
5. Орлон ба хавсран ажиллах ажлын байрны нэр	Шаардлагатай тохиолдолд чанарын менежерийн ажлыг орлон гүйцэтгэнэ.	

“Д” Баталгаажуулалт

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан	Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
<p>Өрх, сум тосгон, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, амаржих газар, клиник, сувилал, төвүүдийн дарга/захирал</p> <p>..... /Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ оны ....сарын ....-ны өдөр</p>	<p>Эмнэлгийн тархвар судлаач</p> <p>..... / Эцэг/эхийн нэрний эхний үсэг, өөрийн нэр/ ..... /Гарын үсэг/ оны ....сарын ....-ны өдөр</p>

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 04 сарын 27-ны өдрийн  
А. дугаар тушаалын 3 дугаар  
169 хавсралт

### Эмнэлэг, тасаг, нэгжид халдвар хяналтын асуудал хариуцсан ажилтны ажлын чиг үүрэг

Эмнэлэг, тасаг, нэгж дэх халдвар хяналтын ажилтан нь орон тооны бус байх бөгөөд халдварын сэргийлэлт, хяналт болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтэн байж болно.

Тухайн асуудлыг хариуцсан ажилтанд нэмэлт хөлс олгох асуудлыг байгууллага шийдэж болно.

Ажилтаны ажлын зорилго: Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх.

Ажлын байрны үндсэн зорилт:

- 1) ХСХ-ын чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих
- 2) ЭТҮХХ-ын тандалт хийх, халдварыг эрт илрүүлэн мэдээлэх, хариу арга хэмжээ авах
- 3) Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авах

Ажлын байрны гол үйл ажиллагаа:

I үндсэн зорилтын хүрээнд:

1. Байгууллагын ЭТҮХХ, ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх
2. ЭТҮХХ-ын эрсдлийг бууруулах, сэргийлэх, хянах, тасгийн эмч, эмнэлгийн ажилтны оролцоог дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах
3. Эрсдэл өндөртэй ажилбаруудыг хянах хуудсаар шалгадаг байх
4. Тасгийн эмч, ажилтнуудын:
  - 4.1. Гар угаах, халдваргүйжүүлэх
  - 4.2. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг зөв, зохистой хэрэглэх
  - 4.3. Хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах
  - 4.4. Цусаар дамжих халдвараас сэргийлэх
  - 4.5. Багаж хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх
  - 4.6. Ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг найруулах, хэрэглэх асуудалд хяналт тавих, хэрэгжилтийг төлөвшүүлэх

5. Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хийгдэж буй ажлын тайланг цаг тухайд нь гаргах, тасгийн эмч, ажилтнуудад танилцуулах, эмнэлгийн тархвар судлаачид хүргэх

II үндсэн зорилтын хүрээнд:

1. ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг хийх, мэдээлэх
2. Үйлчлүүлэгч болон тасгийн эмч, мэргэжилтэнд ЭТҮХХ-аас сэргийлэх мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах
3. ЭТҮХХ-аас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэх, арилгуулах арга хэмжээг авах

III үндсэн зорилтын хүрээнд:

1. Эрүүл мэндийн ажилтаныг халдвараас сэргийлэх зорилгоор дархлаажуулалтанд хамруулах, эрүүл мэндийн байдалд хяналт тавих, үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах
2. Эрүүл мэндийн ажилтан цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, өртөлтийн дараах арга хэмжээг авч ажиллах